



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Хөрөнгө хуваарилах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/186 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/186 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан 440,000,000.0 (Дөрвөн зуун дөчин сая) төгрөгийн хөрөнгийг хавсралтад заасан ажлуудад хуваарилсугай.

2.Хуваарилсан хөрөнгийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг Худалдан авах ажиллагааны алба (О.Содовжамц)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн
А/69 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
2025 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих Дүн
		Эхлэх	Дуусах		
1	ЭМТ "XR-550" гематологийн бүрэн автомат анализатор	2025	2025	64.0	64.0
2	Ерөнхий боловсролын 94 дүгээр сургуулийн спорт заал, дээврийн засвар болон 91 дүгээр сургуулийн барилгын засварын ажил	2025	2025	376.0	376.0
Нийт дүн				440.0	440.0